



**ХЭНТИЙ АЙМГИЙН
БАТНОРОВ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 06 сарын 05 өдөр

Дугаар А/80

Батноров сум


Зээл олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Хүнс, Хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2021 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн А/361 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан “Хоршоог хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журам”, сумын Иргэдийн төлөөлөгчдийн 2024 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн 11 дугаар тогтоолоор батлагдсан төсөл сонгон шалгаруулах хорооны 2025 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. “Хүрдэтийн гурван бүрд” хоршооны “Дайвар бүтээгдэхүүн ангилах, гүн хөлдөөгчтэй зоорь барих” төслийн санхүүжилтэд 80.000.000 (Наян сая) төгрөгийг хоршоо хөгжүүлэх сангаас зарцуулсугай.

2. Зээлтэй холбоотой бичиг баримтын бүрдэл, зээл зээлийн эргэн төлөлтийн хуваарьт хяналт тавьж “Хүрдэтийн гурван бүрд” хоршооны “Дайвар бүтээгдэхүүн ангилах, гүн хөлдөөгчтэй зоорь барих” төслийн санхүүжилтэд 80.000.000 (Наян сая) төгрөгийн зээлийг олгохыг Соёл, сангийн нягтлан бодогч (Г.Цолмонтуяа)-д зөвшөөрсүгэй.

3. Төсөл хэрэгжүүлэгчтэй зээлийн гэрээг хийж, төслийн хэрэгжилт, эргэн төлөлт, ажлын байр нэмэгдэж байгаа байдалд хяналт тавьж үйлдвэрлэл үйлчилгээний тайлан мэдээг сар, улирлаар авч тооцож ажиллахыг Хөдөө аж ахуйн тасгийн Хүнс, жижиг дунд, хоршоо биржийн асуудал хариуцсан мэргэжилтэн (Ч.Чинхүсэл)-д үүрэг болгосугай.

ДАРГА  Г.ОТГОНБАЯР

230425178